

МОНГОЛ УЛСЫН “ОЛОН ТУЙЛТ” ГАДААД БОДЛОГО ХИЙГЭЭД ИХ ГҮРНҮҮДТЭЙ ТОГТООСОН ХАРИЛЦАА

*Наран**

Монгол Улс бол Хятад, Оросын дунд орших эх газрын улс билээ. Хүйтэн дайн дууссаны дараа, Монгол Улсын бие даасан өвөрмөц стратегийн байр суурь нь дэлхийн олон том гүрний анхаарлыг нэн ихээр татсан юм. Монгол Улс өөрийн орны гео-стратегийн онцлогт тулгуурласан “олон туйлт” гадаад бодлого явуулах болж, том гүрнүүдтэй тэнцвэртэй харилцааг идэвхитэй хөгжүүлж, тусгаар тогтнол, аюулгүй байдал, хөгжлийн баталгаагаа хангаж, улмаар үйл ажиллагааны орон зайгаа өргөтгөн олон улсын байр сууриа дээшлүүлж байна.

Нэг. Монгол Улсын “олон туйлт” гадаад бодлого

ЗХУ-ын задрал, Зүүн Европын өөрчлөлт нь Монгол Улсын гадаад орчинг үндсээр нь өөрчиллөө. Монгол Улс нь олон улсын болон дотоод байдлын хувиралтыг дагалдан хуучин тогтолцоогоо өөрчлөв. Улс төрийн талаар, өрнөдийн олон намт парламентийн ардчиллын системд шилжив. Эдийн засгийн талаар, чөлөөт зах зээлийн системийг хэрэгжүүлэв. Гадаад бодлогын хувьд, удаан хугацааны турш баримталсан ЗХУ-ыг дагасан “ганц талыг барьсан” бодлогоосоо татгалзаж эвсэлд үл нэгдэх, ижил тэгш байх, бүх талаар “олон туйлт” гадаад бодлого явуулах боллоо. 1994 онд Монгол Улсын Ардын Их Хуралаас баталсан “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал”-д “олон туйлт” гадаад бодлогыг хуульчилан тогтоосон юм. Энэ “Үзэл баримтлал”-д: “Орос, БНХАУ-тай сайн хөршийн найрсаг харилцаагаа бататгах нь Монгол Улсын гадаад бодлогын гол зорилт мөн” гэж заасаны зэрэгцээ АНУ, Япон зэрэг хөгжингүй улс, бүс нутгийн том гүрнүүдтэй харилцаагаа хөгжүүлж, Монгол Улсын Ази-Номхон далайн бүс нутгийн байр суурийг дээшлүүлнэ гэжээ. Монгол Улсын дэвшүүлж хэрэгжүүлж буй энэхүү гадаад бодлого нь улс орны улс төр, эдийн засаг, цэргийн аюулгүй байдлыг хангах, улмаар стратегийн сонголтоо баталгаатай болгоход үр ашигтай юм.

Монгол Улсын “олон туйлт” шинэ гадаад бодлогын ач холбогдол нь:

*Наран - Өвөр Монголын их сургуулийн хөрш орон судлалын хүрээлэн, шинжлэх ухааны доктор

1. Монгол Улс бол Хятад, Оросын дунд орших эх газрын жижиг улс. Хоёр том хөршдөө илүүтэй түшиглэдэг. Тиймээс ч Монголын орших, хөгжих асуудлыг өмнөд, умард хоёр их гүрнээс салгахын аргагүй. Тусгаар тогтнол, хөгжлөө хадгалан хамгаалахад юуны өмнө хоёр хөрштэйгээ сайн хөршийн найрсаг харилцаатай байх нь чухал.

2. Монгол Улс АНУ, Япон зэрэг хөгжингүй улстай харилцаагаа идэвхитэй хөгжүүлж байгаа ба тэр ч байтугай АНУ-ыг “гуравдагч түнш” гэж үзэж байгаа юм. Энэ нь Монголыг өрнөдийн том гүрнүүдийн улс төрийн дэмжлэг, эдийн засгийн тусламжийг олж авахад төдийгүй их гүрний хүчин чадлын тэнцвэртэй байдалд Оросын нөлөөг Монголд хадгалж чадах юм.

3. Их гүрнүүдийн эвсэлд нэгдэхгүй, том гүрнүүдтэй ижил тэгш харилцаатай байж, аль нэгтэй нь илүү ойртохгүй, мөн дайсагнахгүй байх замаар тусгаар тогтнолоо баталгаажуулж, амьдрах орон зайгаа тэлж болно. Мөн их гүрнүүдийн хүчний тэнцвэрийг улам ашигтайгаар ашиглаж болно.

Хоёр: Монгол Улс ба их гүрнүүдийн харилцаа
Хятад, Монголын сайн хөршийн харилцан итгэлцсэн
түншийн харилцаа

1989 онд Хятад, Монголын харилцаа хэвийн болсоноос хойш, хоёр орны удирдагчид олон удаа харилцан айлчилал хийж, хоёр талын дээд хэмжээний яриа хэлэлцээ үргэлжилсээр байна. Ялангуяа энэ оны 6-р сарын эхээр БНХАУ-ын дарга Ху Зиньтао Монгол Улсад төрийн айлчлал хийж, Хятадын шинэ удирдлагынхан хөрштэйгээ харилцаагаа сайжруулах, түншлэх гэсэн бодлогын илрэл болж, хоёр талын сайн хөршийн найрсаг харилцааг сайн хөршийн харилцан итгэлцсэн түншийн харилцаанд хүргэн дээшлүүлэв. Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди БНХАУ-тай найрсаг харилцан ашигтай хамтын ажиллагааг тууштай гуйвалтгүй хөгжүүлэх нь Монгол Улсын урт удаан хугацааны төрийн бодлого мөн. Монголын тал Хятадын дэвшүүлсэн сайн хөршийн харилцан итгэлцсэн түншийн харилцаа байгуулах зэрэг идэвхитэй саналыг бүрэн сайшаан дэмжиж байна гэж тэмдэглэсэн юм. Хятад Монгол хоёр тал хамтарсан мэдэгдэл гаргав. Мэдэгдэлд хоёр тал харилцан ашигтай худалдаа, эдийн засгийн харилцааг эрчимтэй хөгжүүлэх, байгалийн баялагийг ашиглах, дэд бүтцийг хөгжүүлэх явдлыг хоёр улсын цаашдын хамтын ажиллагааны чухал салбар болгохоор заажээ. Хятад, Монголын харилцаанд хоёр орны худалдаа, эдийн

засгийн хамтын ажиллагаа чухал байр эзэлдэг юм. Одоогоор, Хятад бол Монгол Улсын хамгийн том худалдааны түнш бөгөөд хөрөнгө оруулагч болж байна. Монголын Гаалийн газрын мэдээгээр, 2002 онд Монголын гадаад худалдааны нийт хэмжээ 1 тэрбум 159 сая 900 мянган америк долларт хүрсэнээр Монгол, Хятадын худалдааны 30 орчим хувийг эзлэх болов. Энэ нь хоёр орны харилцаа хэвийн болохоос өмнөх 1987 оны 1,25%-тай харьцуулбал 24 дахин өссөн хэрэг юм. Түүний дотор экспорт 208,9 сая ам. доллар, импорт 132,8 сая ам. доллар болж, Монголын гадаад худалдааны экспортын нийт хэмжээний 41,7%, импортыг 20,2%-ийг эзэлж байна. Хятад Улс бол Монголын хамгийн том экспортлогч орон, хоёрдогч том импортлогч орон юм.

Хөрөнгө оруулалтын талаар, 1990 оноос 2002 оны 10-р сар хүртэл нийт 2332 гадаадын аж ахуйн нэгж Монголд 771 сая ам. долларын хөрөнгө оруулсан ба Хятадын 818 аж ахуйн нэгж 264,5 сая долларын хөрөнгө оруулсан нь Монголд оруулсан гадаадын аж ахуйн нэгжийн 35%, хөрөнгийн хэмжээний 34,3%-ийг эзэлж байна. Хятадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд нь Монголд гол төлөв бага хэмжээний барилга, уул уурхай, хувцас, хүнс, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах зэрэг үйлдвэрлэл эрхэлж байгаа ба томоохон үйлдвэрлэл алга байна. Иймэрхүү байдал нь Хятад, Монголын харилцааны өнөөгийн байдал, хоёр орны эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны хөгжлийн нөөц бололцоонд нийцэхгүй. Энэ удаагийн Ху Зиньтао даргын Монголд айлчлах үедээ хоёр талын хэлэлцэн тогтсон эдийн засаг худалдааны хамтын ажиллагааны чухал салбар болох уул уурхай, дэд бүтцийн салбарт хамтын ажиллагааг эхэлж хэрэгжүүлэх нь хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагаанд шинэ үсрэлт, хөгжил авчирч, хоёр орны харилцааг цаашид хөгжүүлэхэд чухал түлхэц болно гэж найдаж байна. Хятад, Монгол хоёр улс уул уурхайн ашигт малтмалаа хамтарч нээж ашиглах нь хоёр талын хэрэгцээ, эрх ашгийн нэгдмэл чанар, харилцан нөхвөрлөх байдалд урт хугацааны хөгжлийн төлөв нээж өгч байгаа бөгөөд XXI зуунд Хятад, Монголын эдийн засаг худалдааны харилцааны гол хүчин зүйл болох юм.

Монгол, Оросын харилцаа хөгжлийн шинэ үе шатанд орлоо

Өнгөрсөн зууны 90-ээд оны эхнээс Монгол, Орос хоёр орны харилцаа гэнэтийн өөрчлөлт, сэргэлт, хэвийн болох зэрэг адилгүй үе

шатыг тууллаа. 2000 оны 11-р сард Оросын Ерөнхийлөгч В.Путин Монголд айлчилж, Монгол, Оросын харилцааг хөгжлийн шинэ шатанд гаргалаа. Хоёр тал “Улаанбаатарын тунхаглал” гаргаж, хоёр орны харилцааг бүх талаар хөгжүүлэх хандлага, хэтийн төлөвийг тодорхойлов. Ерөнхийлөгч В.Путин Оросын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлд Монгол Улс өвөрмөц онцгой байр суурь эзэлдэгийг тэмдэглэсэн байна. 2002 оны 3-р сард Оросын Ерөнхий сайд М.Касьянов Монголд айлчилж, Монгол, Оросын уламжлалт эдийн засаг, худалдааны харилцааг бүх талаар сэргээн, цаашид өрнөн хөгжих явдлыг ахиулав. Касьянов хэлэхдээ: Орос улс Азийн орнуудтай тогтоосон харилцаандаа Монгол Улстай харилцахыг тэргүүн зэрэгт тавьдаг юм гэжээ. Монгол Оросын хоёр тал хоёр орны харилцааг тойрсон Монголын талаас Орост төлөх өрийн асуудлыг хэлэлцэж, нааштай шийдвэр гаргав. Монголын тухайд гэвэл, Хятад, Оросын дунд оршдог, Зөвлөлтийн үед ч, мөн өнөөдөр ч улс төр-нийгмийн байгуулал, эдийн засгийн систем нь цаг ямагт хойт хөрштэйгээ ойр дотно явж ирсэн ба Орос бол мөнхийн хөрш, түнш нь мөн. Оросын байр суурийг орлуулах зүйл үгүй юм. Хэдийгээр сүүлийн арван хэдэн жил Монгол, Оросын худалдаа буурч байгаа боловч Орос улс Монголын импортын зах зээл дээр ямагт эхний байранд байсаар байна. 2002 онд Монгол, Оросын худалдааны нийт хэмжээ 267 сая 664 мянга 500 ам. долларт хүрсэнээс импортын хэмжээ 224 сая 610 мянган доллар болж, Монголын импортын нийт хэмжээний 34,1%-ийг эзэлж байна. Монголын нефтийн бүтээгдэхүүний бараг 90-ээс дээш хувь, баруун 3 аймгийн эрчим хүч Оросын импортонд түшиглэж байна. 2002 онд Монгол 453622,7 тн нефтийн бүтээгдэхүүн импортолсоноос /110 сая ам.дол/ 419,190 тонныг /982 сая 297 мянган ам.доллар/ Оросоос импортолжээ.

Монгол улс 2002 онд 154,127,000 кВт цаг эрчим хүч /3794800 ам. дол/ импортолсоноос Оросоос 147,710,000 кВт цаг /3,398700 ам.дол/ эрчим хүч импортолсон нь нийт импортлосон цахилгаан эрчим хүчний 89% болж байна.

Монгол дахь гадаад хөрөнгө оруулалтын талаар гэвэл, Орос хэдийгээр урьдын цорын ганц монополь байр сууриа алдсан ч Зөвлөлтийн үед, тусламжаар байгуулсан 3 том цогцолбор үйлдвэрийн бүтээгдэхүүний өртөг Монголын үндэсний нийт үйлдвэрлэлийн 40%-ийг эзэлсэн хэвээр байна. Тэдгээрийн бүтээгдэхүүний экспорт Монголын нийт экспортын 60% болж байна. Энэ 3 үйлдвэрийн нэг болох Орос

Монголын хамтарсан хөрөнгө оруулалттай Улаанбаатар төмөр замын хувьцаат компани Монголын улсын хэмжээний ачаа тээврийн 98%-ийг гүйцэтгэж, Оросын талын 49%-ийн хөрөнгө оруулалттай Монгол, Оросын хамтарсан Эрдэнэтийн зэс молибдений үйлдвэр ба Монголросцветметалл компани бол Монголын 2 том тулгуур үйлдвэр юм. Орос Улс Монголын улс ардын аж ахуйн голлох үйлдвэрлэлийн эрчим хүчийг хангаж, төмөр зам, уул уурхайн салбарт урьдын адил чухал нөлөөтэй хэвээр байна.

Монгол, Америкийн харилцаа анхаарал татаж байна

1987 онд Монгол, Америкийн хооронд дипломат харилцаа тогтоосон бөгөөд эхний үед хоёр орны харилцаа бодитой ахицгүй байлаа. 1990 оноос Монголд үүссэн ардчилсан хөдөлгөөний улмаас улс төрийн байдалд эргэлтийн чанартай өөрчлөлт гарсаны дараа хоёр орны харилцаа сая шинэ шатанд оров. 1991 оноос хойш Америкийн Ерөнхийлөгчийн гэргий Хиллари Клинтон, Төрийн нарийн бичгийн дарга Бейкер, Олбрайт, Ерөнхийлөгч асан Картер болон Америкийн цэргийн Номхон далайн флотын командлагч зэрэг хэд хэдэн дээд зиндааны албаны хүмүүс Монголд айлчилж, Монголын талаас Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Их хурлын дарга нар удаа дараалан хэд хэдэн удаа АНУ-д айлчилла. 2001 оны 11-р сард Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаярын АНУ-д хийсэн айлчлал “9-р сарын 11-ний хэрэг явдлын” дараа АНУ-д айлчилсан эхний 10 улсын удирдагчдын нэг байсанаараа олны анхаарал татсан юм. Хоёр талын удирдагчдын олон удаагийн харилцан айлчлал, хоёр орны улс төр, эдийн засаг болон бүхий л салбарын хамтын ажиллагаанд идэвхитэй урагшлуулагч үүрэг гүйцэтгэв. Улс төрийн хувьд, АНУ эхнээсээ Монголын ардчиллын үйл явцыг дэмжиж, “ардчилсан, эрх чөлөөт, тусгаар тогтносон Монгол Улс байх нь АНУ-ын эрх ашигт нийцнэ” гэж үзэж байна. Эдийн засгийн талаар, АНУ Монголд урт хугацааны нэн тааламжтай нөхцөл олгож, ихээхэн тусламж үзүүлж байна. 1991 оноос хойш АНУ хүмүүнлэгийн үүднээс Монголд жил бүр дундажаар 12 сая ам. долларын эдийн засгийн тусламж өгч, Монголын эдийн засгийн өөрчлөлт, зах зээлийн эдийн засгийг дэмжиж байна. Сүүлийн жилүүдэд хоёр талын худалдаа түргэн хурдацтай хөгжиж, АНУ одоо Хятад, Оросын дараа Монголын гуравдагч том худалдааны түнш орон болоод байна. 2002 онд Монгол, Америкийн худалдааны нийт хэмжээ 181,4 сая ам. долларт хүрч Монголын нийт гадаад худалдааны 15,64%-ийг

зээлж байгаа нь 1992 онтой харьцуулбал бараг 30 дахин өсчээ. Түүний дотор экспорт 158,4 сая ам. доллар болж, Монголын экспортын 31,6%-ийг зээлж байна. Ойрын хэдэн жилд АНУ Монголын хоёрдогч том экспортлогч орны байр сууриа хадгалсаар байна. Монголоос АНУ-д ямааны ноолууран бүтээгдэхүүн, нэхмэл бүс бараа, хүүхдийн хувцас, боловсруулсан, хагас боловсруулсан алт зэргийг голлон экспортлож байна. Монголд оруулж буй хөрөнгө оруулалтын хувьд АНУ хэдийгээр Хятад, Орос/Зөвлөлтийн үеийн хөрөнгө оруулж байгуулсан үйлдвэрүүдийг оролцуулаад/ БНСУ, Японы дараа 5-р байранд яваа боловч Монголд оруулж буй хөрөнгө оруулалтын объект нь цар хүрээ том, урт хугацаагаар ажиллах нефть уул уурхайн олзворлох салбарт чиглэж байна. Аажимдаа бол түүний эдийн засгийн үр ашиг, стратегийн ач холбогдол улам өсөх болно.

Япон бол Монголд хамгийн том хандивлагч орон

1972 онд Монгол, Японы хооронд дипломат харилцаа тогтоосон. 90-ээд оны эхнээс Монголд ардчилсан өөрчлөлт гарсны дараа Монгол, Японы дээд хэмжээний харилцан айлчлал удаа дараа болж, хоёр орны харилцаа хурдацтай хөгжих болов. 1991 оны 8-р сард Японы Ерөнхий сайд Кайфу Монголд айлчилсан нь Япон болоод Өрнөдийн хөгжингүй улсуудаас анх удаа Монголд айлчилсан засгийн газрын тэргүүн байв. Ерөнхий сайд Кайфу Японы Засгийн газар Монголын ардчилал шинэчлэлийн үйл явц ба шинэ түүхэн нөхцөл дэх хоёр орны хамтын ажиллагааг тууштай дэмжиж байгаагаа илэрхийлсэн юм. Монголын удирдагчид ч бас олон удаа “Монгол улс Японыг Ази тив дэх өөрийн гол түнш” гэж үздэгээ илэрхийлж байв. Эдүгээ Монгол, Япон хоёр улс XXI зуунд хандсан бүх талын хамтын ажиллагаа түншлэлийн харилцааг бий болгоод байна. Монгол Улсын шилжилтийн үед тохиолдож буй эдийн засгий бэрхшээлийг Япон улс анхааралдаа авч эдийн засгийн олон төрлийн тусламж үзүүлээ. 1990-2002 онд Монгол Улс Японоос 35,6 тэрбум иений хөнгөлөлттэй зээл авч, 55,6 тэрбум иений буцалтгүй тусламж, 18,8 тэрбум иений шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны тусламж нийтдээ 110 тэрбум иен буюу 1 тэрбум ам. долларын зээл, тусламж авчээ. Эдүгээ Япон улс дэлхийн 160 улсад янз бүрийн тусламж өгч байгаагийн дотор Монголд өгч буй буцалтгүй тусламж 17-р, хөнгөлөлттэй зээл 36-р байранд байж, Монгол Улсын авч буй тусламж дэлхийн олон орноос Японых 1-рт явж байна. Япон Монголд их хэмжээний эдийн засгийн тусламж үзүүлээд зогсохгүй,

мөн олон улсын байгууллага ба хандивлагч орнуудыг Монголд тодорхой хугацаанд тусламж үзүүлэхийг уриалж байдаг юм. 1991-2002 онд Японы Засгийн газар, Дэлхийн Банк зэрэг олон улсын байгууллага Монголд хандивлагчдын чуулгыг нийт 9 удаа хийж, Монголд 3,2 тэрбум ам. долларын тусламж үзүүлэхээр амалсан юм. Өнөөг хүртэл 2,1 тэрбум долларын тусламж 1,2 тэрбум долларын хөнгөлөлттэй зээл, 900 сая долларын буцалтгүй тусламж хэрэгжээд байна. Түүний дотор Японы амалсан тусламжийн хэмжээ ба хэрэгжсэн тусламж зээл хамгийн их бөгөөд нийт тусламжийн 40%-иас дээш юм. Японы Монголд өгч буй эдийн засгийн тусламж нь дэд бүтэц, уул уурхай, аж үйлдвэр, хөдөө аж ахуй, соёл, боловсрол болон аялал жуулчлал зэрэг өргөн хүрээтэй салбарыг хамарч байна.

Гурав. Их гүрнүүдийн дунд Монгол Улсын эзлэх байр суурь

Монгол ба Хятад. Монгол Улс бол Хятадын умард хэсгийн чухал хөрш орон, Зүүн өмнөд, баруун 3 талаараа Хятадтай хиллэдэг. Хоёр орны хилийн шугамын урт 4673 км. Энэ нь Хятадын хуурай газрын хилийн шугамтай 15 улсын дотор хамгийн урт буюу хуурай газрын 20 мянган км хилийн шугамын тавны нэгийг эзэлдэг. Хоёр орны газар зүйн байрлал шийдвэрлэгдсэн, Хятад, Монгол хоёр орон сайн хөрш, сайн нөхөд, сайн түнш билээ. Эргэн тойрны хил тогтвортой байх нь Хятадын шинэ зууны гадаад бодлогын чухал чиглэл юм. Монгол улстай сайн хөршийн харилцан итгэлцсэн түншийн харилцаа байгуулах, харилцан ашигтай хоёр талын эдийн засаг худалдааны харилцааг хөгжүүлэх нь хоёр улсад ашигтай, мөн тогтвортой, баян хүчирхэг цэцэглэн хөгжсөн Монгол Улс Хятадад нэн хэрэгтэй юм.

Монгол ба Орос. Орос, Монголын харилцаа хүйтэн дайны дараа нэг хэсэг хүйтэрсэн нь хоёр талын улс төр, эдийн засаг хийгээд аюулгүй байдлын эрх ашигт сөрөг уршиг авчирсаныг бодит байдал гэрчилж байна. Оросын тухайд гэвэл, Монголтой харилцаагаа шинээр сэргээх нь Оросын Ази Номхон далайн стратегийн чухал бүрэлдэхүүн хэсэг, АНУ зэрэг Өрнөдийн улсуудын Монголд нэвтрэх гарц бөгөөд Монголтой харилцаагаа сайжруулах нь чухал, амин чухал гэдгийг ойлгож байгаа юм. Үүний зэрэгцээ Монголын арвин баялаг ашигт малтмал Оросыг татах хүч юм. Тухайлбал, Оросын цэрэг аж үйлдвэрийн бүхий л хэрэгцээт хайлуур жоншийг монголоос экспортлодог, 2002 онд Монголоос Орост 126,7 мянган тн хайлуур

жонш экспортлосноос гадна /11,798,800 ам. доллар/ үхэр, хонины мах бол Оросын Монголоос импортлодог уламжлалт бүтээгдэхүүн юм.

Монгол ба АНУ. АНУ-ын тухайд, Монголын стратегийн байр суурь чухал юм. Хятад Оросын дунд орших Монгол Улс хоёр том гүрний улс төр, эдийн засаг, соёл иргэншлийн эрх ашгийн огтлолцолын цэг, мөн дэлхийн бүх том шашны хиллэдэг цэг болно. Америк Монголын харилцааг хөгжүүлэх нь Монголын ардчилалыг урагшлуулах төдийгүй, Хятад, Оросын хандлагыг ажиглах, Америкийн гадаад бодлогын стратегид үйлчлэхийн тулд юм.

Монгол ба Япон. Монголтой харилцаагаа чухалчилах Японы зорилго гэвэл: 1. Улс төрийн нөлөөгөө өргөтгөх, Азийн хэрэг явдалд гүйцэтгэх үүргээ дээшлүүлэх, 2. Монголын байгалийн баялагийг нээн ашиглахад оролцох явдал юм. Байгалийн нөөц баялаг хомс Япон улс Монголын ашигт малтмал, аялал жуулчлалын баялагийг машид сонирхож байна. Олон орны нээн ашиглаж буй Монголын ашигт малтмалын зах зээл дээр Япон нь асар их бэлэн мөнгө, тэргүүний технологиороо нэн давуу байдалтай байна.

Дүгнэж хэлбэл, Монголын явуулж буй “олон туйлт” гадаад бодлогыг хүйтэн дайны үеийн “нэг талыг барьсан” бодлоготой харьцуулбал нэлээд эрчимтэй бодлого боловч олон хүчин зүйлийн улмаас хязгаарлагдмал байна. Үүнд:

1. Улс ядуу буурай учраас улсын дотоодод хуримталсан асуудал нэн олон, Засгийн газар дотооддоо ихээхэн хүч анхаарал тавих нь зайлшгүй чухал.

2. Монгол ба олон улсын байгууллагуудад ба олон улс өрийн хүнд дарамтанд байна. Аль болох хурдан гадаад өрөө буцааж төлөхгүй бол шинэ зээл ноцтой нөлөөлөх болно.

3. Монголын хөрөнгө оруулалтын орчин эрүүлжээгүй, дэд бүтцийн цөхцөл, хууль эрхийн үндэс хангалтгүй байна. Хэрвээ эдгээр асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэвэл гадаад худалдаа хөрөнгө оруулалт сайжирна.

4. Монгол Улс их гүрнүүдийн харилцаанд тэнцвэртэй байдлыг хадгалж байх нь бэрхшээлийг давахад хялбар байх болно. Энэ бүхэн нь тодорхой хэмжээгээр Монголын гадаад бодлогын орон зайг өргөтгөх явдлыг хязгаарлаж байгаа юм.

Хятад хэлнээс орчуулсан Л.Бэгзжав